| | | | | | | танхимын сургалтанд усны инженер З.Бахатбол оролцсон бөгөөд уг сургалтаар усны шинжилгээ, судалгааны ажлын явц, үр дүн, цаашдын зорилтын талаар, 2021, 2022 оны Урсац боловсруулахад гарч буй нийтлэг алдааны талаар, мэдээллийн сангийн нөхөн бүрдүүлэлт, техникийн хэргийн баяжилт хийх сэдвийн хүрээнд сургалт явагдсан.<br><br>*Зураг. Сургалт*<br><br>-БОАЖЯ, ЦУОШГазар, БОХЗТЛ-оос зохион байгуулсан “Мөнгөн усны шинжилгээ хийх, тооллого хийх” чадвахжуулах, БОАЖЯ, Тайланд улстай хамтран зохион байгуулсан “Байгаль орчны хор судлал” сэдэвт сургалтанд БОШЛ-ийн эрхлэгч инженер С.Жавзанпагма хамрагдаж, сертификат авсан.<br> | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br><br>*Зураг. Сургалтанд оролцсон нь*<br><br>-УЦУОСМХ-ийн Хөдөө Аж Ахуйн Цаг Уурын Судалгааны Хэлтсээс орон нутгийн ХААЦУ-ын инженерүүдэд “ХААЦУ-ын технологийн шинэчлэл шинжилгээний хөтөлбөрт ажлын чанар, агродундаж мэдээний чанарт анхаарах хяналт тавих чиглэлээр 2 удаагийн цахим сургалт зохион байгуулсанд төвийн ХААЦУ-ын ахлах техникч, салбар хариуцсан инженер нар оролцсон.<br> | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | *Зураг. ХААЦУСХ-ээс зохион байгуулсан цахим сургалт*<br><br>-УЦУОСМХ-ийн Уур Амьсгал Нөөцийн Судалгааны Хэлтсээс орон нутгийн УАНС-гаа хариуцсан инженерүүдийн цахим сургалт зохион байгуулагдсанд төвийн Цаг уурын салбарын инженер техникчид оролцсон.<br><br>-Нислэгийн цаг уурын төвөөс техникчдийн давтан сургалтыг 03 сарын 29-31-ний хооронд цахимаар зохион байгуулж 2 техникч хамрагдсан бөгөөд бодит мэдээний үйлчилгээ үзүүлэх эрхийн хугацаа сунгах шаардлагатай 1 техникч 04 сарын 07-нд цахимаар шалгалт өгч эрх авсан.<br><br>*Зураг. НЦУТ-өөс зохион байгуулсан цахим сургалтанд хамрагдсан нь*<br><br>-БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны байгууллага, Солонгосын Цаг уурын хүрээлэнгийн Олон улсын хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 2023 оны 9 дугээр сарын 4-15-ны хооронд зохион байгуулсан “Цаг уурын ажиглалтын системийг (Монгол улсын) чанарын | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | баталгаажуулалт, ажиглалтын чававхийг бэхжүүлэх тэтгэлэгт хөтөлбөр” сургалтанд төвийн XXXTX-сан ерөнхий инженер Д.Төрмөнх хамрагдаж “ГЭРЧИЛГЭЭ” авсан.<br><br>*Зураг. Сургалтанд хамрагдаж, гэрчилгээ авсан нь*<br><br>-2023 оны 10 дугаар сарын 2-оос зохион байгууллагдсан “Цаг уурын ажиглагчийн курст” цаг уурын өртөө, харуулын 3 техникч, 10 дугаар сарын 30-с эхэлсэн ус судлалын харуулын техникч нарын сургалтанд Алтай-Бодонч, Булган-Байтаг ус судлалын харуулын техникч нар суралцаж мэргэжлийн “ҮНЭМЛЭХ” авсан.<br><br>*Зураг. ЦУОШГ-с зохион байгуулсан техникч нарын сургалтанд хамрагдсан техникчид*<br><br>-Төрийн албаны зөвлөлийн “7:4:10” арга зүйн сургалтыг ТАЗөвлөлөөс 2023.02.09-нд “Ес зүйн зөвлөлийн | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйл ажиллагааны эрх зүйн орчин”, 2023.02.16-нд “Үр дүнд суурилсан нэгдсэн удирдлага” зэрэг сэдвүүдээр зохион байгуулсан цахим сургалтанд хамт олон хамрагдсан.<br><br>-Монгол улсын цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас зохион байгуулсан “Албан бичиг солилцооны дундын системийн хэрэглээ” сэдэвт сургалтанд Хүний нөөц, бичиг хэрэг хариуцсан ажилтан Г.Нямсансар цахимаар оролцсон.<br><br>-“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Удирдлагын академиас зохион байгуулсан бүх шатны төрийн албан хаагчдад таниулах сурталчлах, сургагч багш бэлтгэх цахим болон танхимын сургалтанд /3 дугаар сарын 20-23-ны хооронд цахимаар, 24-25-ны хооронд танхимаар аймгийн төвд зохион байгуулсан/ УЦУОШТ-ийн 2 хэлтсийн дарга нар хамрагдаж “ҮНЭМЛЭХ” авсан. Сургалтанд суусан сургагч нар өөрийн байгууллагын төрийн албан хаагчдад Алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодолгыг таниулах, түгээн дэлгэрүүлэх, хувь хүнийг тодорхой мэдлэгтэй болгох ажил өрнүүлэх, сургалт явуулах чиглэл өгсний дагуу мөн аймгийн ЗДТГ-ын 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 2/721 тоот албан | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бичгийн хүрээнд ажлын хэсэг байгуулж тус ажлын хэсэг сургалтыг 2 удаа зохион байгуулж ажилласан. Удирдлагын академиас 2 дахь удаагийн Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг төрийн албан хаагчдад таниулах, сурталчлах цахим сургалтанд УЦУОШТ-ийн 20 ажилтан сургалтанд идэвхтэй хамрагдаж 80% нь ҮНЭМЛЭХ авсан.  | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>*Зураг.Алсын хараа-2050 сургалт*<br><br>***Аймаг орон нутгаас зохион байгуулсан сургалтууд:***<br><br>-ЗДТГазраас “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийн хэрэгжүүлэх дэд ажлын хэсгийн ХА-н төрийн албан хаагчидтай хийх уузлалтанд төвийн дарга А.Энхзаая, Хүний нөөц, бичиг хэрэг хариуцсан ажилтан Г.Нямсансар, Систем сүлжээний инженер Э.Ганцэцэг нар 2023 оны 01 дүгээр сарын 30-нд оролцсон.<br><br>-ЗДТГазраас бүс нутгийн инноваци эрдэм шинжилгээний хуралд нийт ажилчид 2023 оны 02 дугаар сарын 6-7-ны өдрүүдэд оролцсон.<br><br>*Зураг. Сургалт* | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -ЗДТГазраас 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдөр “Төрийн албан хаагчийн ёс зүй, гйүцэтгэлийн удирдлага” сэдэвт сургалтыг зохион байгуулж ЦУОТХэлтсийн дарга Ц.Дэлгэр, инженер П.Мягмардорж, Хүний нөөц, байгууллагын архив бичиг хэргийн ажилтан Г.Нямсансар нар оролцов.<br><br><br>*Зураг. Сургалтанд оролцсон нь*<br><br>-Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Jica төсөл, Ховд аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Ховд аймгийн ЗДТГазар хамтран зохион байгуулсан МУ дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх төсөл сургалтанд 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Хүний нөөц, байгууллагын архив бичиг хэргийн ажилтан Г.Нямсансар оролцов. | |

*Ховд аймгийн УЦУОШТ-ийн 2023 оны жилийн эцсийн тайлан*

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>*Зураг. Сургалтанд оролцож байгаа нь*<br><br>-МУ-ын шадар сайдын санаачлагаар *“Эрсдэл ба Стандарт эрсдлийн үндэсний форум”-д* төвийн ажилчид оролцсон.<br><br>-ШУА-аас БОНЭЗ-ийн эмзэг байдалд үзүүлэх уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө шинжлэх ухаанд суурилсан бодлого тодорхойлох хэлэлцүүлэгт төвийн 5 ажилтан хамрагдсан.<br><br>-ХОВД ХОТЫН АГААР ОРЧНЫ БОХИРДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ” СЭДЭВТ төрийн байгууллагуудын хамтарсан хэлэлцүүлэгт 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдөр холбогдох сэдвийн дагуу илтгэл мэдээллийг тавьж оролцсон.<br><br>-Аймгийн агаарын бохирдолт, цөлжилтийн талаарх судалгааг гарган судалгааны талаарх мэдээллийг нэгтгэн аймгийн БОАЖГазар, Жаргалант, Мөст суманд илтгэлийг танилцуулсан. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>*Зураг. Сумдын ард иргэдэд агаарын бохирдлын талаар мэдээлэл өгч байгаа нь*<br><br>-Ховд аймагт үйл ажиллагаа явуулж буй БО-ны чиглэлийн байгууллагууд болон төсөл хөтөлбөрийн байгууллагуудын 2023 онд хийж хэрэгжүүлсэн ажил, 2024 онд хийж хэрэгжүүлэх ажлын санал солилцох хэлэлцүүлэгт төвийн хэлтсийн дарга 2023 онд төсөл хөтөлбөрийн байгууллагатай хамтран ажилласан, цаашид хамтран ажиллах санал хүсэлтээ танилцуулж холбогдох мэдээллийг өгч оролцов.<br><br> | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>*Зураг. Төсөл хөтөлбөрүүдийн хамтын ажиллагааны сургалт хэлэлцүүлэг*<br><br>-Аймаг орон нутгаас зохиогдсон төрийн байгууллагын эцэг эхийн зөвлөлийн гишүүдийн сургалт уулзалтанд байгууллагын эцэг эхийн зөвлөлийн гишүүд тогтмол хамрагддаг. Үүнд: *1.* ГБХЗХГазраас Монгол цэргийн өдрийг тохиолдуулан “Бидний бахархалт аав” уулзалтыг зохион байгуулж тус арга хэмжээнд Б. Отгонтөмөр, Т.Хашэрдэнэ, Х.Амарсанаа нар оролцсон.*2.* ГБХЗХГ, Монгол улсын гавьяат жүжигчин Г.Ундармаатай хамтран эцэг эхийн зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалтанд зөвлөлийн 3 гишүүн хамрагдсан. 3.ГБХЗХГазар “Монгол өрх” сэтгэлзүйн хүрээлэнтэй хамтран зохион байгуулсан эцэг эхийн зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалтанд П.Энхжаргал, Б.Даваабал, Э.Оюунтунгалаг нар оролцлоо. 4.10 дугаар сарын 12-нд “ Мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, өсвөр насны хүүхэд, залуучуудыг хорт зуршлаас ангид байлгах” чиглэлээр “АНЗААР” арга хэмжээний хүрээнд хийсэн сургалтанд эцэг эхийн | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөвлөлийн 3 гишүүн оролцсон. 5.10 дугаар сарын 14-нд Монгол Улсын Гавьяат багш Ж. Галбадрах “Хүүхдийн төлөвшилд эцэг эхийн оролцоо” сэдвээр Монгол улсын харцага Т.Амартүвшин “Аавын манлайлал” сэдвээр хийсэн ярилцлаганд хамрагдлаа.<br><br>Байгууллагаас зохион байгуулсан сургалтууд:<br>-УЦУОШТөвөөс цаг уурын 9 өртөө 7 харуулын техникчдэд 2023 оны нэгдсэн сургалтыг цахимаар зохион байгуулж, сургалтанд нийт өртөө харуулын 55 техникч, салбар хариуцсан 10 инженер техникчид нийт 60 гаруй ажилчид хамрагдаж батлагдсан хөтөлбөр, сэдвийн дагуу салбар хариуцсан инженер, ахлах техникчид онолын хичээл заасны зэрэгцээ станц харуулын ажиглалтанд гарч буй үл тохирол, цаашид цаг агаарын үзэгдлийг хэрхэн зөв ажиглах, ажиглалтын мэдээг хэрхэн зөв кодлох, | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дамжуулах талаар заавар зөвлөмжийг өглөө. Мөн төвийн дотоод ажил, ус цаг уурын байгууллага үүсч хөгжсөний 100 жилийн ойн арга хэмжээг угтан зохион байгуулах ажлын төлөвлөгөөг танилцуулж мэдээлэл өгсөн.  *Зураг. Нэгдсэн Цахим сургалт* -Улирлын чанартай ажиглалт эхлэхтэй холбогдуулан Ус судлалын салбарын цахим сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтанд гол, нуур, мөстлөг судлалын 11 харуулын техникч цахимаар оролцлоо. Сургалтыг ус судлалын инженер З.Бахатбол, техникч П.Отгонцэцэг нар удирдаж явуулсан бөгөөд сургалтаар өнгөрсөн оны шинжилгээний ажлын үр дүн, алдаа дутагдалын талаар зааварчилгаа өгч, байгаль орчны шинжилгээний лабораторийн инженер | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | С.Жавзанпагма усны химийн сорьцын үр дүн, шинжилгээний ажлын талаар сургалт өгсөн.<br><br>*Зураг. Ус судлалын салбарын цахим сургалт явуулж байгаа нь*<br><br>-Цаг уурын өртөөдийн **“Туршлага судлах нэгдсэн сургалт”**-ыг 4 дэх жилдээ Мөст сумын Мөст цаг уурын өртөөний хамт олон 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулав. Сургалтанд батлагдсан хөтөлбар, үйл ажиллагааны дагуу төвийн инженер, техникчид болон цаг уурын 9 өртөө, харуулуудын нийт 60 гаруй ажилтан хамрагдав.<br><br>*Зураг. Туршлага судлах нэгдсэн* | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | *сургалт Мөст цаг уурын өртөөнд*<br><br>-УЦУОШТ-ийн нийт албан хаагчдад хууль эрх зүйн болон, хөдөлмөр нийгмийн, эрүүл ахуйн чиглэлээр мэдээлэл өгөх зорилгоор **“Мэдээллийн цаг”-** ийн төлөвлөгөөг оны эхэнд баталж төлөвлөгөөний дагуу тухайн жилийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан сэдвүүдээр Ховд аймгийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн Эрдэнэцэцэг "Ундны усны эрүүл ахуй" сэдвээр мэдээлэл хийлээ. Мэдээллээр Ховд аймгийн хэмжээнд ашиглаж буй гар худгийн болон гүний усанд хийсэн нянгийн шинжилгээ, хатуулаг, эрдсийн шинжилгээний үр дүнг танилцуулж, төвийн ажилчид сонирхсон асуултандаа хариулт авлаа.<br><br><br>*Зураг. Сургалт*<br><br>-Ховд аймгийн Улаан Загалмайн хорооноос ээлжит сургалт, мэдээлэл авлаа. Улаан Загалмайн хорооны мэргэжилтэн Цэцэгзул "Цусны донорын тухай" мэдээлэл сургалт өгөв. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>*Зураг. Сургалт авч байгаа нь*<br><br>-Аймгийн “Газар тариалан эрхлэгчдийн зөвлөгөөн”-нд Дулааны улирлын төлөв болон 6 дугаар сарын урьдчилсан төлөв мэдээгээр МҮХ-ийн дарга М.Баярмаа хичээл зааж оролцсон.<br><br>*Зураг. Зөвлөгөөн дээр мэдээлэл хийж байгаа нь*<br><br>-Ховд аймгийн Хүүхдийн элч, Жаргалант хатан заяа ТББ-н тэргүүн М.Оюунсүрэн ”Хүүхдийн хүмүүжлийн зөрэг арга”, “Гар утас, цахим хэрэглээ”, ”Гэр бүлийн харилцаа”-ны талаар төвийн нийт ажиллагсад болон хүүхдүүдэд мэдээлэл өгч харилцан ярилцлаа. Гэр бүлдээ харилцан хүндэтгэлтэй хандаж, хүрээлэн буй орчиндоо зөрэг зөв энергийг бүрдүүлж байх талаар мэдээллийг өгүүлсэн. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>*Зураг. Аав, ээж, хүүхдүүд сургалт авч байгаа нь*<br><br>-2023-11-14-нийг Чихрийн шижинтэй тэмцэх өдөр болгон зарласантай холбоотойгоор Ховд аймгийн Эрүүл мэндийн газар, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс үзлэг оношлогоог төвийн ажилчдад хийж, “Эрт илрүүлгийн ач холбогдол”,”Чихрийн шижин гэж юу вэ”?, “Халдварт бус өвчин”, “Монгол хүний зөв хооллолт” зэрэг сэвдээр сургалт зохион байгууллаа. Мөн 2023-11-09-нд аймгийн Биеийн Тамир, Спортын Газараас зохион байгуулж буй төрийн албан хаагчдын эрүүл мэндийн сорилд хамт олноороо сургалт авч, төвийн нийт ажилчид биеийн ерөнхий үзлэгт хамрагдсан.<br><br>-Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн байцаагч Бүрэнсайханаар “*Нийгмийн даатгалын багц хуулиудын шинэчилсэн найруулга”, “Тэтгэвэр, тэтгэмж, Сайн дурын даатгал”-ын* талаарх мэдээллийг | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өгүүлсэн.<br><br>-Аймгийн хууль зүйн хэлтсийн мэргэжилтэнгээр *“Авилгын эсрэг хууль, “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”*-аар мэдээлэл сургалт авсан.<br><br>-Хүний эрхийн комиссоос зохион байгуулсан “*Жендерийн эрх тэгш байдлыг хангах”, “Ажлын байрны дарамт, хүчирхийллийн үр дагавар, ажил явуулах, бэлгийн дарамтаас ангид орчин бүрдүүлэх”* чиглэээр явагдсан сургалтанд төвийн ажилчид хамрагдсан.<br><br><br>*Зураг.” Мэдээллийн цаг”-ийн хөтөлбөрийн дагуу хийгдсэн сургалтуудын үйл явц* | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 11.2. | Ажилтнуудыг зэргийн шалгалтад хамруулах, ажлын үр дүн гаргасан ажилтнуудыг шагнаж урамшуулах, төрийн одон медальд тодорхойлох, төвийн нийт ажиллагсдын нийгмийн зарим асуудлыг Байгууллагын дотоод журмын дагуу зохион байгуулах | - | Шалгалтын дүрэм журам мөрдөх, байгууллагын дотоод журмыг баримтлах | 2021 онд мэргэжлийн зэргийн 3-р зэргээр шалгалт өгч тэнцсэн 10 техникч нарын нэмэгдэл хөлс ЗГ-ын 43-р тогтоолын дагуу олгогдоогүй байсан 43-р тушаал цуцлагдсан учир 2022 оноос эхлэн дээрх техникч нарт зэргийн нэмэгдэл цалин хөлс олгогдож эхэлсэн. Байгууллагын дотоод журамд заасны дагуу 2022 онд нийт ажиллагсдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр хамтын сангаасааа 10.128.500 төгрөгийн тусламж дэмжлэгийг үзүүлж ажилласан. | Инженерийн мэргэжлийн 3-р зэргийн шалгалтанд орох 6 инженерын материалыг газарт хүргүүлсэн боловч шалгалт авагдаагүй. Инженерүүдийн зэргийн шалгалт авах ажлыг ЦУОШГазарт уламжлан шийдвэрлүүлнэ. Байгууллагын дотоод журамд заасны дагуу ажилчдын нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлнэ. | УЦУОХШ-ний салбарын инженер, техникчдэд Мэргэжлийн зэрэг олгох Байгаль орчны сайд, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 1996 оны 2 дугаар сарын 22-ны дугаар 22/38/68 тушаал хүчингүй болсноор мэргэжлийн зэрэг авах шалгалт явагдаагүй байсан ба дээрх 3 сайдын тушаал шинэчлэгдэн /2023 оны 8 дугаар сарын 29-ны А/421, А/115, А/170/ гарснаар мэргэжлийн зэргийн шалгалт өгөх хүсэлтэй инженер техникчид шалгалтанд орох хүсэлтээ ЦУОШГ-т хүргүүлсэн. Инженерүүдийн зэргийн шалгалтанд орох 8 инженерийн болон дахин 1, 2, 3 дугаар зэргийн шалгалтанд орохоор хүсэлтээ өгсөн нийт 26 албан хаагчийн материалыг ЦУОШГ-т хүргүүлснээр Систем сүлжээний ерөнхий технологич инженер Э.Ганцэцэг, ЦАЗН Экспидицийн ерөнхий инженер Б.Отгонтөмөр, Ус судлалын ерөнхий технологич инженер З.Бахатбол нар зэргийн шалгалтанд хамрагдаад байна.<br><br>-Байгууллагадаа үр бүтээлтэй олон жил ажилласан дараах албан хаагчдыг БОЯамны “Тэргүүний ажилтан”-аар БОШЛ-ийн инженер С.Жавзанпагм, ус судлалын ахлах техникч П.Отгонцэцэг, нислэгийн үйлчилгээний техникч П.Цацралтуяа, БОАЖЯамны “ЖУУХ БИЧИГ”-ээр Булган-Байтаг ус судлалын харуулын техникч Ц.Батсүх, Мөстөл судлалын | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | инженер Т.Хаш-эрдэнэ, Уур амьсгалын ахлах техникч Б.Даваабал, П.Энхжаргал, Нислэгийн үйлчилгээний техникч Э.Оюунтунгалаг, Хүний нөөц, байгууллагын архив бичиг хэргийн ажилтан Г.Нямсансар, БОШЛ-н инженер Б.Сэлэнгэ, Ус судлалын инженер З.Бахатбол, Синоптик инженер Д.Жаргалсайхан, Дарви ХАА-н харуулын техникч Д.Цолмон, Мөнххайрхан өртөөний дарга Х.Өлзийсайхан, ЦУОШГ-ын "ЖУУХ БИЧИГ"-ээр нярав Н.Отгонжаргал, УМС-н Синоптик инженер М.Ууганболор, Ц.Лхагвасүрэн, нислэгийн цаг уурын техникч Б.Саруултөгс, Ховд өртөөний дарга О.Шинэ-од, техникч Д.Сайханзаяа, Б.Түвшинтогтох, Л.Нямцэцэг, Чандмань өртөөний техникч А.Тунгалаг, Дунд ус өртөөний техникч Ө.Айболды, Ховд-Мянгад ус судлалын харуулын техникч Ц.Энхбаяр нарын 25 албан хаагчийг шагнаж урамшуулсан.<br><br>-Монгол Улсад Ус цаг уурын алба үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ой 2024 онд тохиож байгааг тохиолдуулан өндөр насны тэтгэвэрт гарсан 29 ахмадыг Төрийн дээд шагнал "Алтан гадас", "Хөдөлмөрийн хүндэт", БОЯамны "Тэргүүний ажилтан" шагналаар шагнуулахаар, мөн тус төвд одоо ажиллаж байгаа 1 ажилтанг төрийн дээд шагнал "Алтан гадас" одонгоор, 11 ажилтанг "Хөдөлмөрийн хүндэт" медалиар, | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 15 ажилтанг БОЯамны “Тэргүүний ажилтан”-аар, 5 ажилтанг БОАЖЯамны “Жуух бичиг”-ээр, нийт 61 ажилтаныг дээд газрын шагналд тодорхойлж материалуудыг холбогдох газарт уламжлаад байна.<br><br>Байгууллагын дотоод журамд заасны дагуу төвийн нийт ажиллагсдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарим асуудлыг зохион байгуулж, 2023 оны 11 сарын байдлаар эрүүл мэндийн шалтгаанаар эмчилгээ сувилгаанд явсан, эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн, ар гэрт гачигдал гарсан, хурим найр, ажилчдын гэр бүлд шинэ хүүхэд мэндэлсэн зэрэгт нийт 4.401.000 төгрөгийн тусламж дэмжлэгийг, эх үрсийн баяраар нийт ажилчдад 1920,000 төгрөгний бэлэг, бусад зардалд 2.545.000 төгрөг, мэргэжлийн баяраар 10 ахмад ажилчдад 250,000 төгрөгний гарын бэлэг, 2023 онд тэтгэвэрт гарсан 2 албан хаагчдад 580,000 төгрөгний хүндэтгэлийг үзүүлсэн, Ахмадын баяраар нийт 39 тэтгэвэрт гарсан ахмадуудад нэг хүнд 30000 төгрөгний бэлэг бэлдэж өгсөн. /1170000 төгрөг/<br><br>2023 онд байгууллагын хамтын сангаас нийт 10.845.000 төгрөгний дэмжлэг үзүүлсэн. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>*Зураг. Хамтын сангийн зүйл заалтын дагуу байгууллагын ахмад ажилчидаа хүлээн авч байгаа, тэтгэвэр гарч буй албан хаагчид хүндэтгэл үзүүлж байгаа болон эх үрсийн баярын бэлэг бэлдсэн байдал:* | |
| 11.3. | Төрийн жинхэнэ болон төрийн үйлчилгээний албаны Ёс зүйн зөвлөлийг Засгийн газрын тогтоолын дагуу хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажиллах. | Улсын төсөв | Засгийн газрын холбогдох тогтоолыг бүрэн хэрэгжүүлж ажиллах. | Төвийн даргын 2022 оны 02 дугаар сарын 04-ний А/22 дугаар тушаалаар Ёс зүйн зөвлөлийн гишүүдийг шинээр байгуулан ажиллаж байна.<br><br>2022 онд төвийн Ёс зүйн зөвлөлөөс 3 удаа сургалт зохион байгуулсан. | Байгууллагын Ёс зүйн зөвлөлд ирсэн төрийн албан хаагч, иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдолыг шийдвэрлэж, хариуг хуулийн хугацаанд хүргүүлнэ.<br><br>Ёс зүйн зөвлөл төлөвлөгөөгөө батлуулж, төлөвлөгөөний дагуу ажлаа хийж, сургалт сурталчилгаа зохион байгуулж,ёс зүйн зөрчлөөс ангид байна. | Оны эхнээс УЦУОШТ-ийн дарга нийт 96 албан хаагчтай төрийн албан хаагчийн “Ёс зүйн дүрэм”-ийг сахих талаар хариуцлагын гэрээг байгуулан мөрдөн ажилласнаар ёс зүйн сахилгын зөрчил гаргасан албан хаагч байхгүй. Гэрээг хэрэгжүүлснээр төрийн үйлчилгээний соёл, чанар, хүртээмж шуурхай байдлыг шинэ шатанд гаргах, төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадвар, манлайлал, ёс зүй, харилцаа хандлага, хариуцлага сайжирч байна.<br><br>Байгууллагын Ёс зүйн зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хандлага талаар” сэдвээр аймгийн ТАЗ-ийн мэрэгжилтэнгээр хичээл заалгасан.<br><br><br>*Зураг. Төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх сургалт*<br><br>-Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо, Төрийн албаны зөвлөлөөс санаачлан төрийн албан хаагчийн ёс зүй, манлайлал, гүйцэтгэл, үр дүн, төрийн байгууллагын бүтээмжийг дэмжих зорилгоор зохион байгуулж буй “Төрийн албан хаагчийн ёс зүй, гүйцэтгэлийн удирдлага” сэдэвт чадавхжуулах сургалтыг Төрийн албаны зөвлөлийн Ховд аймаг дахь салбар зөвлөл, аймгийн ЗДТГазар хамтран зохион байгуулсан сургалтанд төвөөс Хэлтсийн дарга Ц.Дэлгэр, инженер П.Мягмардорж, хүний нөөц, бичиг хэрэг Г.Нямсансар нар оролцсон. Мөн дээрх сургалтын хүрээнд байгууллагынхаа албан хаагчдад “Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага” сэдвээр аймгийн Хүний эрхийн сургагч багш, Хүүхэд хамгаалагч М.Оюунсүрэн 2023 оны 11 дүгээр | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сарын 10-ны өдөр төвийн нийт ажилчдад /29 ажилтан/ сургалт зохион байгуулсан.   *Зураг. Төрийн албан хаагчийн ёс зүйн талаар орсон сургалтууд* | |
| 11.4. | Ажилчдын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг ажилдаа мөрдлөг болгон ажиллах | - | Ус судлалын харуулын ажилчид үер усны аюулаас, Мөстөл судлалын инженер техникчид өндөр цас мөстэй ууланд ажиллах, БОШЛ-ийн ажилчид хиймийн хортой урвалж уусмалтай ажиллах, ЦАЗН-лөх экспедицийн пуужин цэнэглэх, газрын генароторчин | Ус судлалын 10 гол, 1 нуурын харуулд ажиллаж байгаа ажилчдад усны гутал хантааз, завь хэрэглэх, өндөр ууланд хамгаалттай гутал, алх, лабораторид ажилладаг ажилчдад халад бээлий, нүдний шилээр хангадаг ч дутмаг, пуужин түлш стандартын шаардлага алдагдсан байдаг тул | Усанд ажиллах, цас мөстэй өндөр ууланд ажиллах, лабораторийн нөхцөлд ажиллах талаар, хамгаалтын хувцас хэрэгсэл байнга хэрэглэх талаар сургалт зохион байгуулж, дээрх албан хаагчидыг хамгаалалтын хувцас хэрэглэлээр хангана. | Ус судлалын харуулуудын цахим сургалтаар Ус судлалын харуулын ажилчид үер усны аюулаас, Мөстөл судлалын инженер, техникчид өндөр цас мөстэй ууланд аюулгүй ажиллах хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг баримтлан ажиллаж байх талаар инженер Б.Отгонтөмөр хичээл заасан. Мөн БОШЛ-ийн инженер, техникчид химийн хортой урвалж уусмалтай ажиллах, ЦАЗНөлөөлөх экспедицүүдийн ажил эхэлсэнтэй холбоотой пуужин цэнэглэх, газрын генераторын түлш цэнэглэх зэрэг ажил үйлчилгээ явуулахад аюулгүй ажиллагааны зааврыг чанд мөрдөн ажиллах талаар зааварчилгаа өгч, бүх эрсдэлтэй | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | түлш цэнэглэх | тогтмол заавар зөвлөмж өгч ажилласан. 2022 онд усны 11 харуулын техникч нарыг усны гутлаар хангасан. | | орчинд ажиллаж байгаа ажилчдаар гарын үсэг зуруулан баталгаажуулж, хяналт тавин ажиллаж байна.<br><br>*Зураг. Усанд ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч байгаа нь*<br><br>БОШЛ-ийн инженер, техникчид лабораторийн урвалж уусмал найруулах, хүчил шүлт бутлах, бэлтгэх үедээ тогтмол аюулгүй ажиллагааны заавар дүрмээ уншиж танилцаад, гарын үсэг зурж баталгаажуулан лабораторийн эрхлэгч хяналт тавин ажилладаг.<br><br>БОШЛабораторийн инженерүүдийг хөдөлмөр хамгааллын стандарт шаардлага, аюулгүй ажиллагааг хангасан ажлын хувцастай болгосон. Мөн БОШЛ-ийн шинжилгээний ажилд ашиглах пипиткийн тавиурыг бүтээлч ажлын хүрээнд хийлгэсэн.<br><br>ЦУОШГ-аас Ус судлалын харуулын техникч нарт өвлийн хувцас /5 ширхэг/-аар хангасан. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | |  *Зураг. Ажилчдыг аюулгүй ажиллагааны хувцас хэрэгслээр хангасан байдал* | |
| **Зорилт-12 Байгууллагын ХХНЖагсаалтын дагуу байгууллагын архивын цаасан суурьтай баримтыг хүлээн авч хадгаламжийн нэгж үүсгэн, данс бүртгэл хөтлөх, хадгалалт хамгаалалтыг сайжруулах.** | | Улсын Төсөв | Байгууллагын архивын цаасан суурьтай материалыг хүлээн авч хадгаламжийн нэгж үүсгэн, данс бүртгэл хөтлөж баталгаажуулах, хөмрөгийн бүрдүүлэлт хийх, даргын А, Б тушаалыг скайнердан цахим сан үүсгэсэн./тоо | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2022 оны албан хэрэг хөтлөлтөөр 11 хадгаламжийн нэгж үүсгэн байгууллагын архивт шилжүүлсэн. Байгууллагын архивын баримтаар хадгаламжийн нэгж үүсгэж ажилласан. | Стандартын дагуу цаасан хэлбэрээр хүлээн авч ХН үүсгэнэ. Хөмрөгийн нөхөн бүрдүүлэлт хийнэ. | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйл /23.2, 23.2.1/ “албан хэрэг хөтлөлтийн явцад үүссэн хавтаст баримтыг зохион байгуулалтын нэгж ажилтанаас бүрэн бүрдэлтэй хүлээн авах” гэсний дагуу байгууллагын архивт 2022 оны 12 нэр төрлийн баримт бичгийг 15 хадгаламжийн нэгж болгон хүлээн авч стандартын дагуу баримт бичгийг үүсгэн хадгалсан, 2022 оны даргын А, Б тушаалыг скайнердаж цахим сан үүсгэсэн.  | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | *Зураг. 1991-2022 оны Байгууллагын даргын А, Б тушаалыг скайнердаж хадгаламжийн нэгж үүсгэсэн байдал*<br><br>Байгууллагын архивт байнга хадгалах 2001-2022 оны 80 хадгаламжийн нэгж, түр хадгалах 2001-2022 оны 107 хадгаламжийн нэгж, 70 жил хадгалах 1983-2022 оны 28 хадгаламжийн нэгж, нийт 27183 хуудас бүхий 215 хадгаламжийн нэгж хадгалагдаж байна.<br><br>БНШК-ын хуралд байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг танилцуулж төвийн даргаар батлуулсан.<br><br>Байгууллагын хадгаламжийн сангийн өрөөний чийг /50-55%/, температурын /+14...+16 градус/ горимын дагуу хэвийн хэмжээнд байлган, хуурай болон нойтон цэвэрлэгээг хуваарийн дагуу тогтмол хийж гүйцэтгэн ажиллаж байна. | |
| 12.1. | Ажилтан, ажиллагсадын хувийн хэргийг зааврын дагуу бүрдүүлэлт хийж, баяжуулах | - | Нийт ажилтан, ажиллагсдын хувийн хэрэгт холбогдох бичиг баримт, хуулбарыг тухай бүр нь нэмж баяжуулсан байх. | 2022 онд шинээр ажилд орсон 5 албан хаагчийн хувийн хэрэгт байх ёстой баримт бичгийг бүрдүүлэн авсан. | Хувийн хэрэгт байх ёстой албан хаагчтай холбоотой баримт бичгүүдийг тухай бүр нь нэмж баяжуулан төрийн албан хаагчийн баримт бичгийн бүрдүүлэлтийг бүрэн хийнэ. | Боловсон хүчинтэй холбоотой тушаал, хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолт, шагнал, холбогдох сертификат зэргийг ажилтаны хувийн хэрэгт хавсарган баяжилтыг тухай бүр нь хийж, 3 хэлтэс, 9 өртөө, 18 харуулын хувийн хэргийн хавтасыг нэг өнгөөр жигдрүүлэн хавтасыг шинэчлэн бүрдүүлэлт хийсэн. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | |  *Зураг. Төрийн албан хаагчийн хувийн хэрэг.* Шинээр ажилд орсон 2 албан хаагчийн хувийн хэргийг шинээр үүсгэн холбогдох бүх бичиг баримтууд /тушаал, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ, төрийн албан хаагчийн анкет 1, 2-р маягт, намтар, дипломын нотариатаар батлуулсан хуулбар гэх мэт/-ыг авч бүрдүүлсэн. | |
| 12.2. | Төрийн албан хаагчийн бүртгэл, тайланг csc.gov.mn цахим хуудсанд өөрчлөлт, хөдөлгөөнийг заавар, журмын дагуу шинэчлэн бүртгэх | - | Албан хаагчдын үндсэн цалин, нэмэгдэл болон бусад өөрчлөлтүүдийг цалин бодогдохоос өмнө тушаалын дагуу шинэчилсэн байна. | 2022 онд 97 ажилтаны хувийн мэдээлэл болон цалин хөлс, нэмэгдэлийн мэдээллийг 1-12 сар хүртэл тухай бүр нь шинэчлэн оруулсан. | Албан хаагчдын мэдээллийг үнэн зөв бүртгэснээр сар бүрийн цалин, нэмэгдлүүд төрийн албаны цалингийн нэгдсэн системд татагдсан байна. | Төрийн албаны /hrm.csc.gov.mn/ ХНУМТ цахим системд байгууллагын албан хаагчдын мэдээллийг шинэчлэн бүртгэсэн. Мөн өөрчлөлт хөдөлгөөнийг тухай бүр нь төвийн даргын тушаалын дагуу цахим системд бүртгэж байна. Нийт ажилчдны хоол, унааны хөнгөлөлтийг ажилтан тус бүрээр, үндсэн цалин, нэмэгдэл цалин хөлсийг тухайн сард нь өөрчлөлт орсон ажилтаны хөдөлгөөнийг бүртгэж хэвшсэн. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | |  *Зураг. Төрийн албаны ХНУМТ-д ажилчдынхаа мэдээлэл шинэчилж оруулсан байдал* | |
| 12.3. | Байгууллагад ирсэн иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэлтийн мэдээ, тайланг хугацаанд нь хүргүүлэх | - | Ирсэн өргөдлийн шийдвэрлэлтийн тоо, хэрэгжилт (хувиар)-мэдээ, тайлан хүргүүлэх хэрэгжилт (хувиар ) | 2022 оны 11 дүгэр сарын 30-ны байдлаар 39 өргөдөл хүлээн авч хугацаанд шийдвэрлэж ажилласан. | Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэнэ. | Иргэд болон албан хаагчдаас 14 өргөдөл ирснийг хүлээн авч, хуулийн хугацаанд 100% шийдвэрлэж, хариуг холбогдох иргэн, аж ахуйн нэгжид өгөв. Аймгийн Засаг даргын 2017 оны А/131 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн төрийн байгууллага, албан тушаалтанд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын хүрээнд өргөдлийн шийдвэрлэлтийн мэдээ тайланг улирал бүр аймгийн ЗДТГазарт хугацаанд нь хүргүүлсэн. | 100 |
| 12.4. | 12.4. ХАСХОМ–ийг холбогдох албан тушаалтан, байгууллагын нийт ажилчид хувь хүний орлогын албан татварын тайланг хуулийн хугацаанд гаргаж тайлагнасан байх | - | Мэдүүлэх хүний тоо Хуулийн хэрэгжилт хангасан байдлаар (хувиар) | ХАСХОМ–ийг 4 албан тушаалтан, Хүний орлогын албан татварын тайланг 96 ажилтан 2022 оны 2-р сарын 15-аас өмнө хуулийн хугацаанд | Хуулийн хугацаанд ХАСХОМ-ийн болон Хувь хүний орлогын албан татварын тайланг хуулийн хугацаанд тайлагнана. | Авлигын эсрэг хуулийн 10.3 заалт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23.3-т заасны ХАСХОМ-ын мэдүүлгээ төвийн дарга болон 3 хэлтсийн дарга нар 2 дугаар сарын 05-наас өмнө гаргаж газрын ЭБАТ-д хүлээлгэн өгч хугацаандаа баталгаажуулан | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тайлагнасан. Хэрэгжилт 100% | | дээшээ мэдүүлсэн.     *Зураг. Мэдүүлэг гаргагч 4 албан хаагчийн баталгааны маягт.* | |
| 12.5. | Салбарын холбогдох хууль тогтоомж, Ерөнхийлөгч зарлиг, УИХ, Засгийн газрын тогтоол шийдвэр сайдын тушаалын хэрэгжүүлэх тайлан мэдээллийг нэгтгэн холбогдох байгууллагад цаг хугацаанд нь хүргүүлэх. | - | Тухайн шийдвэрүүдийг хяналтанд авч хэрэгжилтийн тайланг тухай бүр гарган хүргүүлэх/тоо | Хэрэгжилтийн тайланг хагас жилээр хугацаанд нь цаасан байдлаар гаргаж хүргүүлсэн ба 11 сараас манай аймаг Төрийн мэдээллийн сүлжээ системд шилжснээр 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайланг цахим байдлаар хүргүүлж ажиллаж байна. | УЦУОХШ-ний салбарын хамаарал бүхий хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтийг цаг хугацаанд нь хэрэгжүүлж ажиллана. | УЦУОХШТухай хууль түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм журмын хэрэгжилт зөрчилгүй хангалттай байж, ЗГ-ын 2023 онд гаргасан 2023 оны 241,242, 243,301,98 дугаар тогтоолууд, МУ-ын БОАЖСайд,ХНХСайд,Сангийн Сайд нарын хамтарсан А/421,А/11,А170 дугаар тушаал,БОАЖСайдын А/243 дугаар тушаалуудыг тус тус мөрдөн хэрэгжүүлэн ажиллав.<br><br>Ховд аймгийн засаг даргын захирамж 3, албан даалгавар 2, Жаргалант сумын засаг даргын захирамж 6, БОАЖЯамны Сайдын тушаал 1, ХА-н Онцгой комиссын тогтоол 1, тушаал 1, ЦУОШГазрын даргын тушаал 31, төвийн даргын А тушаал 23, Б тушаал 45, явуулсан бичиг 445, ирсэн бичиг 149 үүнээс хугацаатай хариутай 38 бичиг ирж цаг хугацаанд нь хариуг нь өгч ажиллав.<br><br>2023 оны 01 дугаар сарын 02-ны өдрөөс Төрийн байгууллагын | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цахим систем https://intranet.gov.mn/ цахим сүлжээнд нэвтрүүлсэн ба байгууллага хоорондын албан бичгийг тус сүлжээг ашиглан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж ажиллаж байна.<br><br>*Зураг. Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлага*<br><br>-МУ-ын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2023-03-17-ны ХЭГ/595 тоот, аймгийн Засаг даргын 2023-03-28-ны 2/484 тоотоор ЗГ-ын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн чиглэлийн дагуу тодорхой ажил зохион байгуулж тус байгууллагад ажилд орсон ажилтан албан тушаалтан танилын болон зүй бус нөлөөллөөр, хуульд заасан шаардлага хангаагүй этгээд томилогдсон эсэхийг шалгаж тогтоохоор Авлигатай тэмцэх “Шүүр” ажиллагааны хүрээнд төвийн нийт 96 ажилтаны албан | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тушаалын тодорхойлолт, ажилд орох өргөдөл, эзэмшсэн мэргэжил зэрэгт байгууллагын 3 хэлтсийн дарга нар, зөвлөлийн гишүүд, хүний нөөц, бичиг хэрэг хариуцсан ажилтантай хамтран хяналт үнэлгээ, шалган тогтоох ажлуудыг зохион байгуулж “ШҮҮР” ажиллагааны хүрээнд холбогдох хууль тогтоомж, шаардлагыг зөрчиж ажилд томилогдсон албан хаагч Ховд аймгийн УЦУОШТөвд байхгүй ба тус ажиллагааны тайлан мэдээг хүргүүлж ажилласан.<br><br>-Авилгатай тэмцэх газраас Авилгатай тэмцэх 5Ш арга хэмжээний "Шүгэл" ажиллагааны хүрээнд улс орон даяар өрнүүлж буй авилгын эсрэг үйл хэрэгт иргэн бүрийн оролцоог ханган хүнд суртал, чирэгдлийг бууруулах, авилгыг мэдээлж шүгэл үлээхийг уриалсан "Нэгдье" соён гэгээрүүлэх аянд Ховд Ус, Цаг уур орчны шинжилгээний төв нэгдэн ажиллаж байна.<br><br>*Зураг. Шүгэл ажиллагаанд нэгдсэн нь* | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 12.6. | Салбар нэгжид шалган туслах ажил зохион байгуулж, аргазүйн зөвөлгөө өгөх | - | Цаг уурын 9 өртөө, ХАА-н цаг уурын 7 харуул, ус судлалын 11 харуул, мөстөл судлалын харуулд ажилласан тоо | 2022 онд төвийн харъяа 30 салбар нэгжид 1-2 удаа газар дээр нь ажиллаж заавар зөвлөмж өгч, шалган туслах ажил хийгдсэн. | Нийт 30 салбар нэгжид очиж аргазүйн зөвөлгөө зааварчилгааг өгч УЦУОХШТехнологийг мөрдүүлнэ. | Шинжилгээний хөтөлбөрт ажлын хэвийн тасралтгүй байдлыг хангуулах үүднээс шалган туслах ажлыг энэ онд цаг уурын өртөө, харуул, ус судлалын харуулуудад давхардсан тоогоор 1-2 удаа шалган туслах ажлыг төвийн салбар хариуцсан технологич инженерүүд, хэлтсийн дарга нар салбаруудад ажиллахдаа бүх төрлийн шинжилгээний хөтөлбөрт ажлын явц, ажилд гарч байгаа үл тохиролд аргазүйн заавар зөвөлгөө өгөх, бүх багаж тоног төхөөрөмжийн үзлэг үйлчилгээ хийх, шалгаж тохируулах, харьцуулсан тоолол авах, тухайн өртөө харуулуудын албан хаагчдад шаардлагатай хичээл сургалт явуулах, ажиллах орчин нөхцөл, шаардлагатай байгаа багаж төхөөрөмж, цэвэрлэгээний материал, бичиг хэргийн материал гэх мэтээр хангаж, техникчдын мэргэжлийн мэдлэг шалгах шалгалт авах ажлуудыг шалган туслах ажлаар хийж гүйцэтгэсэн. Шалгалтаар шинжилгээний бүх багаж тоног төхөөрөмжийн ажиллагаа хэвийн байлаа. Цаг уурын Мянгад харуулын талбайд автомат багаж төхөөрөмжийг суурилуулж байрлуулсан. Чандмань цаг уурын өртөөнд UPS шинээр тавьсан, цаг уурын харуулуудад хөрсний мэдрүүрийн ажиглалтанд зориулж хөрсний жааз хийж өгсөн. Цэцэг, Мөст, Мөнхайрхан Дунд ус өртөөдийн AWS310, AWS330 автомат станцуудад автомат станцын | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | батерей сольсон. Үенч цаг уурын харуулын флюгерийг буулгаж будан самбарыг хүнд самбар болгож байрлуулсан.<br><br>Ус судлалын голын 10 харуул, нуурын 1 харуулд шалган туслах ажил хийж, шалгалтын нивлередлэгийг хийж хөдөлсөн шонгуудын засвар шинээр гаргасан.<br><br>ХААЦУ-ын бүх чиглэлийн ажлыг шалгаж заавар зөвлөмж өгөхийн зэрэгцээ БТБ-ын ажиглалтыг төвийн ХААЦУ-ын инженер, техникч Дуут, Дөргөн, Мянгад сумын 14 цэгт тус ажиглалтыг хийлцэж, аргазүйн зөвөлгөө өгч ажиллав.<br><br> | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>*Зураг. Шалгах туслах ажлын явц* | |
| 12.6. | Орон нутаг байгууллагаас зохион байгуулсан олон нийтийн ажилд оролцсон байдал | - | Олон нийтийн зохион байгуулсан ажил/тоо | Дээд газар, аймаг орон нутаг, байгууллагаас зохион байгуулсан олон нийтийн ажилд хамрагдаж оролцсон байдал | 2022 онд манай байгууллагын нийт ажилчид орон нутгаас зохион байгуулсан ажилд идэвхтэй оролцсон | -Аймгаас зохион байгуулсан өвлийн цас мөсний баяр “МӨНГӨЛӨГ ШАГШУУРГА-2023” арга хэмжээнд төвийн хамт олон гэр барьж, 2 өдрийн гэрийн үйлчилгээнд ажиллахаас гадна тухайн өдрүүдийн цаг агаарын урьдчилсан төлөв мэдээгээр нийтэд үйлчлэсэн.<br> | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | *Зураг. Мөсний баяр*<br><br>-“INVEST KHOVD ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ФОРУМ 2023” арга хэмжээний 2 өдрийн үйл ажиллагааны сургалт хэлцүүлэгт төвийн дарга, хэлтсийн дарга, инженерүүд идэвхитэй оролцов.<br><br><br>*Зураг. Хөрөнгө оруулалтын форум*<br><br>-Дэлхийн цаг уурын байгууллагаас жил бүрийн 03 сарын 23-ны өдрийг Цаг уурчдын тэмдэглэлт өдөр болгон тунхагласан байдаг. Энэ жилийн дэлхийн цаг уурчдын өдрийг “ХОЙЧ ҮЕДЭЭ ҮЛДЭЭХ ИРЭЭДҮЙН ЦАГ АГААР, УУР АМЬСГАЛ, УС” сэдвийн дор УЦУОШТөвөөс “Мэргэжил сурталчлах аян”-ныг 3 дугаар сарын 18-22-ны хооронд БОШЛ-ийн хамт олон хүрээлэн буй орчны бохирдол, доройтол, усны нөөцийн хомсдол, түүний зохисгүй хэрэглээг багасгах чиглэлээр видео шторк байдлаар хийж, байгууллагын пэйж хуудсаараа дамжуулан ард иргэдэд танилцуулж байгууллагын | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйл ажиллагаагаар сурталчлав.<br><br>-Хамтын ажиллагаатай байгууллагууд хамтарч бүс нутагт бэлтгэгдэж буй байгаль хамгаалах чиглэлийн мэргэжлийн оюутнуудын мэдлэг чадварыг дээшлүүлэх, эзэмшиж буй мэргэжлийнх нь үнэ цэнэ, хэрэгцээ шаардлагыг ойлгуулах уулзалт хэлэлцүүлэг хийсний зэрэгцээ УЦУОШТ-ийн Байгаль орчны шинжилгээний лаборторит хийгддэг мониторингийн судалгааны багаж тоног төхөөрөмжийг танилцуулсан.<br><br>*Зураг. Мэргэжил сурталчилах аяны хүрээнд*<br><br>-Байгууллагын өнгө үзэмж болон хаврын хуурайшилтыг бууруулах зорилгоор байгууллагын ойр орчмын 50м2 талбайн мод бутанд голоос мөс татан, тавьж, цэнэг усалгааг хийв | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>*Зураг. Сааданд мөс тавьж цэнэг усалгаа хийсэн байдал*<br><br>-Ховд аймгийн Жаргалант сумын засаг даргын тушаал /2023.03.06 А/50 тоот/ бүх нийтийн хог цэвэрлэгээний ажил зохион байгуулах аян 2023 оны 03 дугаар сарын 09-ны өдрөөс эхлэн 09 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл сар бүрийн 2,4 дэх долоо хоногийн Пүрэв гаригт зохион байгуулах аянд манай байгууллага нэгдэж, өөрийн эзэмшлийн болон түүний ойр орчмын 50 м хүртлэх газраа бүрэн цэвэрлэж, энэ онд хог цэвэрлэгээний ажил зохион байгуулах тухай ирсэн албан бичгүүдийн дагуу “Эрүүл аюулгүй Цэвэр орчин”, ”Шарилж зэрлэг ургамлыг цэвэрлэх тухай„ -”Буянт голын сав дагуу газарт бүх нийтийн хог цэвэрлэгээний ажилд хамт олноороо оролцож, цэвэрлэсэн хогоо төвлөрсөн хогийн цэгт хүргэж, тус ажлын тайланг сар бүрийн 20-ны дотор Жаргалант сумын тамгын газарт | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүргүүлэн ажилласан.<br><br>*Зураг Бүх нийтийн цэвэрлэгээний явц*<br><br>-Хог хаягдлын хуулийг хэрэгжүүлэх зорилгоор аймгаас ирүүлсэн чиглэлийн дагуу байгууллагаас гарч байгаа хогийг ангилан ялгаж хийх хогийн савыг хаягдал материал ашиглан хийж байршуулав.<br> | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br><br>*Зураг.Хогийн сав хийж байршуулав*<br><br>-“ИРЭЭДҮЙХЭЭ ТӨЛӨӨ БУЯНТ ГОЛОО ХАЙРЛЪЯ” чалленжид нэгдэж Ховд Ус Цаг Уур Орчны Шинжилгээний Төвийн хамт олон 2023-05-05-ны өдөр Бугат үзүүрээс доош бага голын усан доторх болон голын эрэг, голын урд талын хашаалсан торон хашаануудын араар цэвэрлэгээг хийж, хүрээлэн буй орчны бохирдлыг багасгаж хог цэвэрлэх ажилд хамт олон идэвхтэй оролцож, түүсэн хогоо хогийн нэгдсэн цэгт хүргэсэн.<br><br> | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>*Зураг. Буянт голын хог цэвэрлэв.*<br>“Цусаа бэлэглэх өдөр”-ийг тохиолдуулан ШИНГЭН ЭРХТЭН ЦУСАА бэлэглэх аянд нэгдэж төвийн хамт олон нийт 2.4 литр цус бэлэглэв.<br><br><br><br>*Зураг. Хамт олон Цусаа бэлэглэв*<br><br>-Монгол улсад цаг уурын байгууллага үүсэж хөгжсний 100 жилийн ойг угтсан төлөвлөгөө гаргаж 1 жилийн хугацаанд хийх ажлаа эрэмбэлэн эхнээс нь хийж байна. Ойг угтаж 100 ширхэг мод тарьж ургуулах ажлын хүрээнд хаврын тариалалтаар нийт 70 ширхэг мод тарьсан. Мөн хамт олныхоо дунд 100 жилийн ойг угтсан 5 төрөлт /шатар, даам, дартс, гар бөмбөг, оюун ухааны/ спортын арга хэмжээг зохион байгуулж шалгарсан баг | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүрэлдэхүүнд гарын бэлэг шилжин явах цом гардуулсан ба энэ нь цаг уурын 100 жилийн спортын бүсийн арга хэмжээнд оролцох хувь хүн, баг хамт олноо тодруулах зорилготойгоор явуулсан ба цаашид жил бүр уламжлал болгон зохион байгуулж байхаар болов.<br><br>*Зураг. Тэмцээнд тэргүүлсэн САAХ-ийн баг хамт олон*<br><br>-ХҮМҮҮН БИЧИГ-ХҮН БҮРИЙН БИЧИГ УРАЛДААНД ОРОЛЦОВ. “Хос бичигтэн Ховдчууд” аяны хүрээнд үндэсний бичгээ эрхэмлэн дээдэлж түгээн дэлгэрүүлэх, төрийн албан хаагчдын монгол бичгийн хэрэглээний чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Ховд аймгийн соёлын газраас зохион байгуулж буй "Хүмүүн бичиг-Хүн бүрийн бичиг" уралдаанд тус төвийн хамт олны төлөөлөл оролцож монгол бичгийн мэдлэг чадвараа сорин өрсөлдлөө. Уралдаан түргэн уншлага, уран бичвэр, цахим бичвэр, багийн ахлагчийн даалгавар, монгол бичгийн дүрмийн асуулт хариулт гэсэн төрлүүдээр явагдсан ба | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийлбэр дүнгээр 2-р байранд шалгарсан амжилтыг үзүүллээ. Ус судлалын салбарын инженер З.Бахатбол минутанд "хамгийн олон үг" уншиж түргэн уншигчаар шалгарав.<br><br>*Зураг. Уралдаанд оролцсон баг*<br><br>-Нийгмийн хариуцлагын хүрээнд ажиллагсдын гэр бүл, хүүхдэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж, хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байгууллагын албан хаагчдын хүүхдүүдэд зориулсан “**Хүүхдийн өрөө”**-тэй болсон.<br><br>Байгууллагын дотоод журманд дараах зүйл заалтуудыг шинээр нэмж тусган мөрдөн ажиллаж байна. Үүнд:<br><br>1.Төрийн албан хаагчийн гэр бүл, үр хүүхэддээ гаргах цаг завыг зохицуулж 0-16 насны хүүхдийнхээ төрсөн өдрийг тэмдэглэхэд хагас өдрийн цалинтай чөлөө олгох<br>2.Хүүхдүүдийнхээ эрүүл мэндэд нь анхаарч 0-16 насны хүүхдээ эмнэлэгт үзүүлэх, шинжилгээ | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өгөхөд хагас өдрийн цалинтай чөлөө олгох 3.Бага насны /0-3 / хүүхдээ эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх тохиолдолд эцэг эхчүүдэд цалинтай чөлөө олгох.<br><br>Байгууллагын дэргэдэх Эцэг эхийн зөвлөл нь хөдөлмөрийн тухай хуулийн 43.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий Сайдын тэргүүлдэг хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 03 тоот тогтоолыг хэрэгжүүлэх, байгууллага, албан хаагчид, хүүхдүүдийн хамтын үйл ажиллагааг идэвхжүүлэх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор тус төвийн хамт олон тодорхой хандив гарган байгууллагын эцэг эхийн зөвлөлийнхэн манлайлан "Хүүхдийн өрөө"-г тохижуулж бэлэн болгож ажилчдын бага насны хүүхдүүд тус өрөөнд өөрийн дуртай зүйлээ хийж, аав, ээжийн ажиллах нөхцлийг хангаж байна.<br><br> | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>*Зураг. Хүүхдийн өрөөнд байгаа ажилчдын үр хүүхдүүд аав ээжийнхээ ажил тарахын хүлээх зуур тоглож байгаа нь.*<br><br>“Хүүхэд зодож шийтгэхийн эсрэг” олон улсын өдрийг угтан “Нэгдүгээрт хүүхэд” олон талт нөлөөллийн арга хэмжээг 04 сарын 25-ны өдөр эцэг, эх , хүүхдүүдийн дунд зохион байгууллаа. Энэ өдөр хүүхдүүд аав ээжийнхээ ажилтай танилцаж, хүүхдийн өрөөндөө тоглож, хоорондоо танилцаж, хөгжилтэйгөөр нэг өдрийг үдлээ. Хүүхдүүддээ үдийн цай өгч, дархлаа дэмжих витамин, гарын бэлэг өгч бяцхан үрсээ баярлууллаа.<br><br><br>*Зураг. Хүүхдүүд аав ээжийнхээ* | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | *ажилтай танилцав*<br><br>Эх үрсийн баярыг тохиолдуулан 5 дугаар сарын 31-нд төвийн нийт ажиллагсадын /96/ хүүхдүүдэд бэлэг өгч баярлууллаа.<br><br><br>*Зураг. Хүүхдийн бэлэг*<br><br>-Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “ТЭРБУМ МОД” үндэсний хөтөлбөр, жил бүрийн 5-р сарын 2 дахь 7 хоногийн бямба гараг буюу 2023-05-13-ний өдөр бүрийн бүх нийтээр мод тарих өдрийн хүрээнд болон Монгол улсад цаг уурын алба үүссэний 100 жилийн ойг угтаж 100 ширхэг мод тарих ажлын хүрээнд тус төвийн хамт олон Ховд олон улсын нисэх буудлаас доош чиглэлд зам дагуу 70 ширхэг улиас модны суулгацыг тарьж Ногоон хөгжилд хувь нэмрээ оруулан ажиллалаа. УЦУОШТ-ийн ажилчид байгууллагын эзэмшлийн сааданд цэцэг, байгууллагын хашаанд гоёлын цэцэг тарьж суваг шуудууг сэргээсэн. Түмэн модот хаалга арга хэмжээний хүрээнд байгууллагын эрчүүд 3 удаа ажиллаж нөхөн тарилтаар 230-аад модыг тарьж нийт 300 гаруй мод тарьсан. УЦУОШТ-ийн хамт олон намрын мод тарилтаар 55 ширхэг | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мод тарьж, цэнэг усалгаа хийв.<br><br>*Зураг. Мод тарилт,байгууллагын гаднах ногоо орчин*<br><br>-Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар хэрэгжүүлж буй Эрүүл Монгол Хүн үндэсний хөдөлгөөн, "Цаг гаргая-Ховдчууд 2023" аян биеийн тамирын арга хэмжээ, Эрүүл мэндийн яамнаас зарласан Энэ жилдээ-Эрүүл жиндээ аяны хүрээнд тус төвийн хамт олон ажлын байрны дасгал хөдөлгөөнийг тогтмол хийж нэгдэв. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>*Зураг. Дасгал хөдөлгөөнд цаг гаргая аянд оролцсон нь*<br><br>-Аймгийн Нийтийн номын сангийн газраас НОМТОЙ ӨГЛӨӨ-НОМТОЙ НӨХӨРЛӨЕ арга хэмжээ зохион байгуулж манай төвийн хамт олонд мэдээлэл өгч ном уншихын ашиг тусын талаар ярьж, ажилчид гэрээр ном унших карт нээлгэн Номтой нөхөрлөв.<br><br><br>*Зураг. Номын танилцуулга*<br><br>-ГАМШГИЙН АЮУЛЫН ЗАРЛАН МЭДЭЭЛЛИЙН ДОХИОГООР БҮХ НИЙТИЙН ДАДЛАГА, СУРГУУЛЬД төвийн "ЦАЦРАГ ХИМИЙН АЮУЛЫГ ЗАРЛАН МЭДЭЭЛЛЭХ ШТАБ"-ын баг бүрэлдэхүүн бэлтгэл байдлаа ханган оролцов. “Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага"-аас зарласан "Бэлэн бай" дадлага сургуулалт 6 дугаар сарын 08-ны | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 16:00 цагт улс орон даяар нэгэн зэрэг гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дадлага, сургалтын ДОХИО-гоор Ард Аюушийн талбайд "ЦАЦРАГ ХИМИЙН АЮУЛЫГ ЗАРЛАН МЭДЭЭЛЛЭХ ШТАБ"-ын баг бүрэлдэхүүн дадлага сургуулалтыг хийж, гамшгийн үеийн бэлэн байдлыг хангаж оролцов.<br><br>*Зураг. Бэлэн бай сургалтаар*<br><br>-“Баруун монгол, түүний хил залгаа нутгийн байгалийн нөхцөл, нөөц” олон улсын эрдэм шинжилгээний XVI хуралд БОШЛ-ийн инженерүүд оролцсон.<br><br>*Зураг. Эрдэм шинжилгээний XVI хурал*<br>-Увс, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай аймгийн Байгаль орчны салбарт ажиллаж буй | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эмэгтэйчүүдийн “Олуулаа нэгдэж асуудлаа шийдье” 2 дахь удаагийн уулзалт, хэлэлцүүлэг 10-р сарын 3-6 хооронд Увс аймагт зохион байгуулсан арга хэмжээнд Байгаль орчин аялал жуулчлалын газар болон Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргааны мэргэжилтэн, Сумын Байгаль орчны байцаагчид, Ус цаг уур орчны шинжилгээний төв, Байгаль хамгааллын төсөл хөтөлбөрт ажиллаж байгаа нийт 70 гаруй эмэгтэй төлөөлөгчид хамрагдахад тус төвөөс 3 эмэгтэй албан хаагч оролцлоо.<br><br>*Зураг.Эмэгтэйчүүдийн чуулга уулзалт*<br><br>-Жил бүр Байгаль орчны салбар байгууллагуудын ажилчдын дунд зохион байгуулагддаг уламжлалт тэмцээн 2023-11-04-ний өдөр зохион байгуулагдаж, уг тэмцээнд 11 багийн тамирчид спортын 4 төрлөөр өрсөлдөж оюун ухаан, хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн.<br> | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>*Зураг. Тэмцээнд оролцсон баг тамирчид*<br><br>-Төрийн болон үйлчилгээний байгууллагуудын хүртээмжийг сайжруулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй тэгш хамруулагч байгууллагын тоог нэмэгдүүлэх зорилгоор "Хүн бүрд ээлтэй хүртээмжтэй Ховд-*2"* аяны хүрээнд байгууллагынхаа хүртээмжийн үнэлгээг хийж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд гаднаас орох тусгай зам, авто машины зогсоол гаргаж тохижуулав.<br><br><br>*Зураг.Хөгжлийн бэрхшээлтэй иргэд орох зам хийсэн байдал*<br><br>-Хүүхдийг ахуйн осол гэмтэл, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, орчны эрсдэлийг бууруулах чиглэлээр орон даяар хэрэгжиж буй "Хамтдаа шалгая-Хамгаалъя" арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан албан байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоотойгоор хүүхдэд ээлтэй, эрүүл аюулгүй | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | орчныг бүрдүүлэх, хүүхдийг болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, байгууллагын гадаад, дотоод орчин, албан хаагчид болон тэдний хүүхдүүдийн оршин суугаа газар, сургууль, цэцэрлэгийн орчны аюулгүй байдлын үнэлгээг асуумжийн хүрээнд хийж Ховд аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран ажиллав.<br><br><br>*Зураг. Аянд нэгдсэн нь* | |
| УЦУОШТ-ийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан нийт 74 зорилтот арга хэмжээ, нэмэлтээр хийсэн 6 арга хэмжээний /80/ хэрэгжилт эхний 11 сарын байдлаар. | | | | | | | **92.75** |

ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ЦУОШГ-ЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Л.ОЮУНЖАРГАЛ

..............................

ТАЙЛАГНАСАН:

ХОВД АЙМАГ УЦУОШТ-ИЙН ДАРГА А.ЭНХЗАЯА

...............................